

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Олон улсын эрүүл мэндийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2019-10-16		ЗТ-19/10-012	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Эрүүл мэнд, эмчилгээний зардал					
	Даатгалын үндсэн эрсдэл	Ердийн өвчин, халдварт өвчин, гэнэтийн осол					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.12%-2.4%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Нөхөн төлбөр олгохгүй нөхцлүүд: Дараах үйл баримтууд нотлогдсон тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй:

- 1.1. Даатгалын багцын тусламж үйлчилгээний хязгаараас давсан тохиолдолд
- 1.2. Даатгагчаас олгосон урьдчилан зөвшөөрлийг хэтрүүлсэн тохиолдолд мөн тухайн эрүүл мэндийн шалтгаан нь даатгалын гэрээний дагуу олгогдохгүй нөхцөл байвал даатгуулагч гарсан зардлыг өөрөө хариуцна.
- 1.3. Нөхөн төлбөрийн материалыг шаардлагатай тохиолдолд эх хувиар ирүүлээгүй бол
- 1.4. Нөхөн төлбөрийн өргөдлийн маягтыг бөглөх эмчийн зардал болон аливаа бичиг баримтын зардал
- 1.5. Даатгуулагч нөхөн төлбөр нэхэмжлэх материалыг хуурамчаар бүрдүүлсэн, хуурамчаар бүрдүүлснийг нь тогтоосон тохиолдолд
- 1.6. Эмчийн зөвлөгөөг үл харгалзан гадагшаа явах болон 28 долоо хоногтойгоос дээш жирэмсэн хүн агаарын тээврээр аялж байх тохиолдлоос үүдэн гарах зардал
- 1.7. Хүлээлтийн хугацаанд гарсан аливаа эмчилгээ үйлчилгээний зардал
- 1.8. Гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөх ёстой даатгалын хураамж төлөгдөөгүй байх хугацаанд гарсан болон даатгалын гэрээ хүчин төгөлдөр бус байх үед гарсан эмчилгээ үйлчилгээний зардал;
- 1.9. Баримтаар батлагдаагүй аливаа эмчилгээ үйлчилгээний зардал
- 1.10. Энэхүү гэрээний 7.3.2-т заасан хугацаанаас хойш ирүүлсэн бүхий л нөхөн төлбөрийн материалын дагуух зардал
- 1.11. Нөхөн төлбөрийг нэхэмжлэхдээ даатгалын компанид худал, бүрэн бус эсвэл төөрөгдүүлэх мэдээлэл өгөх, аливаа мэдээллийг нуун дарагдуулсан, даатгалын компаниас шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзсан, нөхөн төлбөр гаргуулахаар гуравдагч этгээдтэй хуйвалдсан, хууран мэхэлсэн нь тогтоогдсон, ямар нэг үндэслэлгүйгээр нөхөн төлбөр нэхэмжлэх зэрэг тохиолдолд нөхөн төлбөрийг олгохгүй бөгөөд тухайн Үндсэн даатгуулагчийн даатгалын гэрээг цуцалж болно. Дээрх шалтгаануудын улмаас тухайн Үндсэн даатгуулагчийн даатгалын гэрээг гэрээ эхэлсэн өдрөөс цуцлах эрхтэй ба даатгалын хураамжийг буцаан олгохгүй байх эрхтэй;

2. Даатгалын нөхөн төлбөрт хамаарахгүй эрсдлүүд:

- 2.1. Мансууруулах бодис, согтууруулах ундаа, эмчийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй эсэхээс үл хамааран эм тариаг хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүдэн гарах эмчилгээ үйлчилгээний зардал;
- 2.2. Харшил тодорхойлох зорилгоор хийгдэх үснээс авдаг шинжилгээ, харшлын мэдрэг чанар болон хоолны харшлыг саармагжуулах тарианы зардал төлөгдөхгүй ба арьснаас харшлыг тодорхойлох шинжилгээ даатгалын нийт хугацаанд 1 удаа төлөгдөнө;
- 2.3. Йога, (bone-setting), бүтэн биеийн болон хэсэгчилсэн бариа засал, бүх төрлийн усан болон усан физик эмчилгээ, бүдүүн гэдэсний цэвэрлэгээ, нуруу нугаламын хоорондын зайг тооцоолох /IDD/, толгойнд цахилгаан массаж хийх, хүнд металын хордлого тайлах эмчилгээ, байгалийн эмчилгээ, татлага, арьсан доор эм шахах, толгойн массаж, аюурведийн эмчилгээ, эм тариа, биокинетикийн гимнастик, сэтгэл судлалын яриа, хүний биеийг цахилгаан гүйдлээр эмчлэх, даралтат цэгэн бариа, рейкийн эмчилгээ, бясалгал, био энергийн эмчилгээ, соронзон эмчилгээ болон богино долгионы эмчилгээ болон оношлогоо;
- 2.4. Задлан шинжилгээтэй холбоотой аливаа зардал;
- 2.5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч аливаа байгууллага, эмнэлэг болон эмчийн үйл ажиллагаа, бүртгэлийн хураамж, мөнгөн шилжүүлэгтэй холбогдон гарах бүх төрлийн зардал;
- 2.6. Удамшлын гаралтай болон төрөлхийн аливаа согог, өвчин эмгэгтэй холбоотой аливаа зардал;
- 2.7. Энэхүү гэрээнд заасан тусламж үйлчилгээний багцын жирэмслэлт болон төрөлттэй холбоотой эмчлгээ үйлчилгээнээс бусад жирэмслэлттэй холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээний зардал болон жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, ерөндөг тавиулах, авахуулах, үрийн суваг боолгуулах, үргүйдлийн эмчилгээ, бэлгийн сулрал, өнгөний өвчин, бэлгийн замын халдварт өвчин, хүйс солиулахтай холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээний зардал;
- 2.8. Даатгуулагчийн сайн дураар хийлгэж буй гоо сайхны мэс засалтай холбоотой аливаа зардал. Мөн нөхөн сэргээх мэс засал, өөх соруулах, биеийн илүүдэл эд эсийг авах, хөх томруулах болон багасгах зэрэг эмчийн зааврын дагуу хийлгэх эсэхээс үл хамаарах биеийн хэлбэрийг өөрчлөх, засахтай холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээний зардал болон эмчийн жорын дагуу эсэхээс үл хамааран гоо сайхны бүтээгдэхүүний зардал төлөгдөхгүй;
- 2.9. Венийн судасны бүдүүрлийг мэс заслын болон мэс заслын бус аргаар эмчлэх эмчилгээ үйлчилгээний аливаа зардал;
- 2.10. Хууль бус үйлдэл, гэмт хэрэгт холбогдсоны улмаас авсан гэмтэлтэй холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээний аливаа зардал;
- 2.11. Хэл ярианы бэрхшээл, ярианы гажиг засахтай холбоотой эмчилгээ үйлчилгээний зардал;
- 2.12. Хоолны дуршил алдагдах, жингийн илүүдэл болон дутагдалтай холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээ, эмчийн зөвлөгөөний зардал болон сэтгэцийн шалтгаантайгаар хоолны дуршилгүй

- болох (anorexia), сэтгэцийн шалтгаантайгаар хоолны дуршил ихсэх (bulimia), тураах мэс ажилбар (bariatric) зэрэг эмгэгтэй холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээний зардал;
- 2.13. Туршилтын эм бэлдмэл, эмчилгээ болон тэдгээрээс үүдсэн аливаа хүндрэлтэй холбоотой зардал;
 - 2.14. Даатгалын гэрээний жилд тохиолдсон гэнэтийн ослын гаралтайгаас бусад нүдний хараа сайжруулах болон гажиг засах мэс засалтай холбоотой аливаа зардал. Солир нүд болон солир нүдний зовиурын эмчилгээ;
 - 2.15. Эмчийн зааврын дагуу хийгдэх эмчилгээ үйлчилгээг дагаж мөрдөөгүйгээс хожим үүдэн гарах аливаа эмчилгээ үйлчилгээний зардал;
 - 2.16. Урагт хийгдэх хагалгаа;
 - 2.17. Тавхайн өвчин, хөл арчилгаа, хумс засал, явдал засах аливаа эмчилгээ;
 - 2.18. Генийн шинжилгээ болон генийн инженерчлэлтэй холбоотой аливаа зардал;
 - 2.19. Зориулалтын багаж хэрэгсэл ашиглан усанд шумбах, хад болон ангал, хавцал руу авирах, дельтапланаар нисэх, уулын болон спорт шүүрээр нисэх, агаарт шумбах, мэргэжлийн спортын үйл ажиллагаанд оролцох, дотоод шаталтын хөдөлгүүр бүхий машин болон техник хэрэгслээр уралдаан тэмцээнд оролцсоны улмаас үүдэн гарах аливаа эмчилгээ үйлчилгээний зардал; Аливаа зохион байгуулалттай спортын үйл ажиллагаанд оролцох;
 - 2.20. Рашаан сувилал, амралт, уламжлалт эмчилгээний зардал.
 - 2.21. Төрөлхийн болон хөгшрөлтөөс үүдэлтэй дүлийрэл, сонсгол дэмжих хэрэгсэлтэй холбоотой эмчилгээ үйлчилгээний аливаа зардал;
 - 2.22. Хүний Дархлал Хомсдын Вирус (ХДХВ), ДОХ-р өвчилсөн үед илрэх хавсарсан хам шинжүүд (ARCS), ДОХ болон түүнээс гаралтай бүх төрлийн өвчинтэй холбоотой эмчилгээ үйлчилгээний аливаа зардал;
 - 2.23. Эмчилгээний зорилгоор хийгдсэнээс бусад хүчилтөрөгчийн барокамерын эмчилгээний зардал;
 - 2.24. Үргүйдлийн эмчилгээ үйлчилгээний аливаа зардал;
 - 2.25. Бөөрний архаг өвчлөлтэй тохиолдолд давтан болон урт хугацааны бөөрний диализийн эмчилгээ үйлчилгээний аливаа зардал. Гэхдээ даатгалын хамгаалалтанд багтсан бөөр шилжүүлэн суулгах хагалгааны өмнө болон дараа яаралтай хийгдэх 4 долоо хоног хүртэлх богино хугацааны бөөрний диализийн эмчилгээ төлөгдөнө;
 - 2.26. Эрэгтэй болон эмэгтэй цэвэршилт, цэвэршилтийн өмнөх үйл явц, өсвөр насны шилжилт, сарын тэмдэг ирэхийн өмнөх өөрчлөлт, гормоны эмчилгээ зэрэг байгалийн жамаар бий болдог бие организмын аливаа өөрчлөлттэй холбоотой эмчилгээ үйлчилгээний зардал;
 - 2.27. Аливаа шалтгааны улмаас бий болсон хамрын таславчтай холбоотой аливаа эмчилгээ үйлчилгээний зардал;
 - 2.28. Хөнгөвчлөх эмчилгээний зардал. Энэ нь илаарших боломжгүй хүнд өвчтэй хүмүүсийн амьдрал, өвчний төгсгөлийн шатанд өвдөлт, зовиур, шаналгааг хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хэлнэ;
 - 2.29. Даатгалын гэрээ эхлэхээс өмнө бий болсон биеийн өмнөх эрүүл мэндийн байдалтай холбоотой эмчилгээ үйлчилгээний зардал;
 - 2.30. Архаг хууч өвчний хяналтын эмчилгээ, шинжилгээ, оношлогоо, эм тарианы зардал;
 - 2.31. Сэтгэцийн эмчилгээ болон сэтгэцийн шалтгааны улмаас үүдсэн эмчилгээний зардал;
 - 2.32. Халзралын эмчилгээ, хиймэл үсний зардал;
 - 2.33. Даатгуулагчийн аялж, албан томилолтоор явж байгаа эсэхээс үл хамааран ууланд төөрөх, цана, чаргаар гулгаж яваад алга болох, төөрөх, говь, цөл, ой шугуй, ширэнгэ зэрэг бөглүү газарт төөрөхөд эрж хайх зардлыг төлөхгүй ба далайн гүнээс тос гаргах зэрэг оффшор бүсэд байгаа газар, далайд байх үеийн усан онгоц, бирвааз болон дарвуулт онгоц зэрэг дээрээс нүүлгэн шилжүүлэлт хийх зардал;
 - 2.34. Урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр хийлгэсэн онош баталгаажуулах үйлчилгээний зардал болон шинжилгээг давхардуулан хийсэн зардал;
 - 2.35. Санаатайгаар өөрийн бие махбодийг гэмтээх, гэмтэл учруулах, амиа хорлох үйлдэл хийх, хийхээр завдах /хэвийн болон сэтгэцийн өөрчлөлттэй эсэхээс үл хамааран;/амиа хорлосон тохиолдолд шарилыг эх орон руу зөөвөрлөх, оршуулах, чандарлах зардал/;
 - 2.36. Нойргүйдэл, унтах үеийн амьсгал тасалдах, хурхирах зэрэг нойртой холбоотой оношлогоо, шинжилгээ, эмчилгээний зардал;
 - 2.37. Чөмөг шилжүүлэн суулгах хагалгааны өмнө шаардагдах чөмөг цуглуулах үйлчилгээтэй холбоотой зардал;
 - 2.38. Таяг, тэргэнцэр, чиг мод зэрэг туслах хэрэгслийг нийлүүлэх, суурилуулах, хөлслүүлэхтэй холбоотой зардал. Мөн бусад хиймэл үе болон бүхий л хиймэл эрхтэн, түүнийг бэлтгэх, суулгах зардлыг төлөхгүй. Бүхий л төрлийн электрон болон механик эрүүл мэндийн/мэс заслын туслах хэрэгслийн эвдрэл гэмтэлтэй шууд болон шууд бус холбоотой гарсан зардлыг мөн төлөхгүй;
 - 2.39. (Tourette) синдромыг оношлох, эмчлэхтэй холбоотой аливаа зардал;
 - 2.40. Нүүлгэн шилжүүлэх, буцаан тээвэрлэхтэй холбоотой тусламж үйлчилгээнд тусгаснаас бусад байрны болон тээвэрлэлтийн зардлыг төлөхгүй;

- 2.41. Зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлдэг болон эрх бүхий байгууллагаас нислэг үйлдэх тусгай зөвшөөрөл бүхий арилжааны зориулалттай нисэх онгоцоос бусад агаарын тээврийн хэрэгсэл ашиглан хийсэн нислэгт оролцох;
- 2.42. Дайн, олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан болон үймээн самуунд оролцох, цэрэг дайны бэлтгэл сургуулилтад оролцох, радио идэвхит хорт бодис ашиглах, хууль бус аливаа эрүүгийн гэмт хэргийн шинж чанартай үйлдэлд оролцох;
- 2.43. Өөрийн буруутай үйлдлийн улмаас эрүүл мэнддээ хохирол учруулсан тохиолдолд /өөрийн буруутай үйлдэл гэдэг нь урьдчилан сэргийлэх боломжтой, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй гэдгийг мэдэж байсан тохиолдлыг хэлнэ/; Жишээ нь: мацаг барьснаас үүдэлтэй эрүүл мэндэд үүсэх асуудал/;
- 2.44. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас бусад гуравдагч этгээдийн зүгээс шаардаж буй үйлчилгээ, шинжилгээний зардал (виза хүсэх, гадаадад зорчих, сургуульд элсэх, ажилд орох, бассейнд явах, албан томилолтоор явах зэрэг);
- 2.45. Шаардлагагүй тохиолдолд хийлгэсэн болон өөрийн дур мэдэн хийсэн эмчилгээ үйлчилгээний зардал;
- 2.46. Гэрээнд өөрөөр заагаагүй бол нэг цаг хугацаанд болсон түүний үр дагавраар цөмийн, химийн, биологийн алан хядах үйл ажиллагааны шууд болон шууд бус үр дагавараас бий болсон, нөлөөлсөн, шалтгаалсан, холбоотойгоор үүссэн зардал. (Цөмийн, химийн болон биологийн алан хядах үйл ажиллагаа гэдэг нь ямарваа нэг улс төр, шашин, үзэл суртлын зорилгоор засгийн газарт нөлөөлөх, бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор даатгуулагч хувь хүн болон бүлэг хүмүүс нь даатгалын гэрээний хугацаанд химийн, цөмийн болон биологийн шингэн, хатуу биет болон хийн бодисыг гаргах, суллаж тавих, тараах, цацах зэрэг ямар нэгэн байдлаар ашиглахыг хэлнэ.);
- 2.47. Даатгалын хамгаалалт үйлчилэх бүс нутгаас гадна хийгдэх яаралтай бус эмчилгээ үйлчилгээ;
- 2.48. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон хоол шим тэжээлийн зөвлөгөө, илүүдэл болон дутуу жинтэй холбоотойгоор хийгдэх аливаа зөвлөгөө, шинжилгээ, эмчилгээний зардал;
- 2.49. Эмчийн жорын дагуу эсэхээс үл хамаарах аливаа витамин болон аминдэмийн зардал;
- 2.50. Эмчийн жоргүй авсан аливаа эм тарианы зардал;
- 2.51. Эмчийн жорын дагуу эсэхээс үл хамааран улс орон даяар зохион байгуулалттай импортлогдож байгаа эм тариа (Harvoni, Sofosbuvir гэх мэт);
- 2.52. Шүдний эмчилгээ үйлчилгээ